



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн 2020 оны төсөв батлах тухай” 10 дугаар тогтоолын дагуу тус сургуулийн албан хэрэгцээнд зориулан нийт 1,521,832,240.00 (нэг тэрбум таван зуун хорин нэгэн сая найман зуун гучин хоёр мянга хоёр зуун дөчин) төгрөгт багтаан хавсралтад заасан төсөл арга хэмжээг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх замаар үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн, Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн захирал Т.Хэрүүга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



0000078

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 02 дугаар сарын // -ний
өдрийн дугаар тогтоолын хавсралт

Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн 2020 онд хэрэгжүүлэх
төсөл, арга хэмжээний жагсаалт

Д/д	Төсөл арга хэмжээний нэр төрөл, хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Төсөвт өртөг
				(мян.төгрөг)
	1. Барилга, их засвар			
1	Эдийн засаг, бизнесийн сургуулийн номын сангийн өргөтгөлийн барилгад санхүүжилт	багц	1	1,361,832.24
2	Мал эмнэлгийн сургуульд малын үзлэгийн байр барих /Өлзийт хороололд орших/	багц	1	60,000
	2. Тоног төхөөрөмж			
3	Компьютер	ш	20	50,000.00
	3.Тавилга эд хогшил			
4	Сандаал	ш	200	20,000.00
5	Ширээ	ш	100	30,000.00
Барилга, их засварын дүн			2	1,421,832.24
Тоног төхөөрөмжийн дүн			20	50,000.00
Тавилга эд хогшлын дүн			300	50,000.00
				1,521,832.24
Нийт дүн			322	(нэг тэрбум таван зуун хорин нэгэн сая найман зуун гучин хоёр мянга хоёр зуун дөчин)